

БХБ-ЫН САЙДЫН ЗӨВЛӨХ Б.ЭНХБОЛД УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦТАЙ ТАНИЛЦАВ



Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөх Б.Энхболд, Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Алтайбаатар нар 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монголын МСС-нд ажиллаж, Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцлаа. онголын МСС-ийн Гүйцэтгэх захирал Э.Содонтогос Компакт гэрээний санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, хэрэгжилтийн явцын талаар товч мэдээлэл өгөв. Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход тавигдсан урьдчилсан болзолт нөхцөлүүдийн биелэлтийг хангахад

Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) шаардлагатай бүхий л дэмжлэгийг үзүүлж, чухал үүрэг гүйцэтгэснийг энэ үеэр онцлоод, цаашид төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд, тэр дундаа Төв цэвэрлэх байгууламж руу үйлдвэр, аж ахуйн газруудаас нийлүүлж буй хаягдал усан дахь химийн бодисын агууламжийг 2013 оны түвшин, эсхүл түүнээс бага хэмжээнд хүргэх зорилго бүхий “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах болон бусад тодорхой асуудлуудаар дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг энэ үеэрээ хүслээ. Ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг Улаанбаатар хотын 2030 оны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан учир шинээр байгуулагдах Шинэ зуун мод, Майдар зэрэг дагуул хотуудыг усаар хангах боломжтой бөгөөд үүний тулд шинэ эх үүсвэрээс ус татах инженерийн байгууламж, шугам, хоолойн дэд бүтцийг эртнээс төлөвлөх шаардлагатайг энэ үеэр мөн дурдлаа.

Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сан

ШИНЭ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРСНООР БОХИР УСНЫ 25 ХУВИЙГ ДАХИН АШИГЛАНА



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Сонгинохайрхан дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нар тус дүүрэгт барьж буй Төв цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын явцтай танилцлаа. Шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор хоногт 250 мянган шоо метр бохир ус хүлээн авах бөгөөд тус байгууламжийн дэргэд Мянган сорилтын хоёр дахь Компакт гэрээний санхүүжилтээр Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр байгуулснаар нийт бохир усныхаа 25 хувийг дахин ашиглаж, III, IV цахилгаан станц руу нийлүүлж, энэ хэрээр Улаанбаатар хотын цэвэр усны хэрэглээнд хэмнэлт гарна. Шинэ ТЦБ-ийг ашиглалтад оруулахын тулд гурван том ажил хийх ёстойг энэ үеэр танилцууллаа. Нэгдүгээрт, шинэ ТЦБ-тай бохир усны хоолойг холбох ёстой. Гачуурт тосгоноос Дүнжингарав хүртэл 20 км газрын шугам угсралтын ажил хийгдсэн. Дүнжингараваас Төв цэвэрлэх байгууламж хүртэлх 10 км шугамын угсралтыг шинэ ТЦБ-ийг 2023 оны наймдугаар сард ашиглалтад оруулахаас өмнө буюу 2022 онд багтаан энэ ажлыг хийж дуусах шаардлагатай. Хоёрдугаарт, төв цэвэрлэх байгууламжийн цахилгааны дэд станцын хүчин чадлыг хоёр дахин нэмэх ёстой. 2018 оноос хойш үүнийг Улсын төсөвт суулгахаар ажиллаж байгаа ч одоог хүртэл чадаагүй тул үүнд анхаарахыг Ерөнхий сайдаас хүссэн юм. Гуравдугаарт, ирж байгаа лагийг хатааж, шатаах үйлдвэр байгуулна. ТЭЗҮ, зургийн ажил хийсний дараа төсөв нь тодорхой болно гэлээ.

Эх сурвалж: Нийслэл Засаг даргын Тамгын газар

ТОВЧХОН

- BOAJA-ны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн “Цахим хөтөч”-өөс “Ус хэрэглэгч, ашиглагчдад олгох зөвшөөрлийн тухай” мэдээллийг хүлээн авах боломжтой. [Эх сурвалж: Цэнгэг усны нҮҮЦ, байгаль хамгаалах нҮБ](#)
- УСУГ-ын Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг “[Усны чанар, аюулгүй байдал](#)” болон “[Авлага барагдуулах үйл ажиллагаа хүндрэл бэрхшээл](#)” сэдвээр хүргэж байна. [Эх сурвалж: УСУГ](#)
- ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Геологи, Гидрогеологийн салбараас Усны инженер хөтөлбөрийн хүрээнд “[Та үндны усныхаа талаар хэр сайн мэдэх вэ?](#)”, “[Хэрвээ Ус бидэнтэй ярилцаж чаддагсан бол Юу гэх байсан бол...](#)” зэрэг сонирхолтой мэдээллийг хүргэжээ. [Эх сурвалж: ШУТИС - Усны инженер хөтөлбөр /Гидрогеологи мэргэжил/](#)

УСНЫ СЭДЭВТ ЦАХИМ ХУРЛУУД

- Америкийн Усны Ажилчдын холбоо буюу AWWA-гаас ээлжит вэбинараа “Эх үүсвэрээс цооргонд хүртэл усны чанарыг хадгалахад дижитал шийдлүүдийг хэрхэн ашиглах боломжтой вэ?” сэдвээр зохион байгуулна. Вэбинар Улаанбаатарын цагаар 2021 оны 6 дугаар сарын 4-ний 01.00AM-02.00AM цагт болох бөгөөд [энэ холбоосоор](#) мэдээлэл авч, бүртгүүлэх боломжтой. [Эх сурвалж: AWWA](#)
- Хот, суурин газрын усны менежментийн асуудлаарх дэлхийн хамгийн том арга хэмжээнүүдийн нэг болох “Сингапурын Олон улсын усны долоо хоног” 2021 оны 6 дугаар сарын 22-ноос 7 дугаар сарын 2-ны хооронд цахимаар зохион багуулагдана. [Эх сурвалж: SIWW](#)